



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/100

Жаргалант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.4, 4.4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 16-р хорооны Засаг дарга, нийгмийн ажилтангууд 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр тус сумын нийгмийн ажилтангуудтай хамтран туршлага солилцох арга хэмжээнд зориулж 790,000 (долоон зуун ер мянга) төгрөгийг зарцуулсугай.
2. Туршлага солилцох арга хэмжээний төсвийг хавсралтаар баталсугай.
3. Туршлага солилцох үйл ажиллагааны удирдамж, хөтөлбөрийг боловсруулан батлуулж, зохион байгуулсан ажлын тайлан, зарцуулсан санхүүгийн тайланг ажлын 3 хоногт багтаан танилцуулахыг Хүүхэд, гэр бүл нийгмийн ажилтан (Г.Анхзаяа)-д даалгасугай.
4. Дээрх зардлыг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

232501292

Сумын засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 22 өдрийн 1/100 дугаар
захирамжийн хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 16-Р ХОРООНЫ
ХАМТАРСАН БАГИЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

2025 оны 10 сарын 22 нд

№	Бараа, зүйл	Тоо хэмжээ /нэгж/	Үнэ (төгрөг)
1	Хүлээн авалт	15 хүн /2 удаа/	490,000₮
2	Гарын бэлэг	6ш	300,000₮
	Нийт дүн	-	790,000₮

БАТЛАВ:
ТАМГЫН ДАРГИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНГӨНТУЯА



ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 16-Р
ХОРООНЫ ХАМТАРСАН БАГИЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

1. Зорилго:

Хүүхэд хамгааллын хамтарсан багуудын хамтын ажиллагаа, туршлага солилцох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах.

2. Зорилт:

- Хамтарсан багийн гишүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх
- Ажлын туршлага хуваалцах
- Хамтын ажиллагааны туршлагыг солилцох

3. Үндэслэл:

Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн дүрэм, орон нутгийн бодлого, төлөвлөгөөнд тулгуурлан зохион байгуулна.

4. Зохион байгуулагч:

Норовлин сумын ЗДТГ, Хамтарсан баг

5. Хамтран зохион байгуулагч:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 16 хороо, Хамтарсан баг

5. Хугацаа, газар:

- Хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр
- Газар: Хэнтий аймгийн Норовлин сум
- Байрлах газар: Норовлин сумын ЗДТГ-ийн зочид буудал

**ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 16-Р
ХОРООНЫ ХАМТАРСАН БАГИЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Огноо	Хугацаа	Үйл ажиллагаа	Оролцогчид / Байршил
10-р сарын 09 (Пүрэв)		Туршлага солилцох хамтарсан баг Норовлин суманд ирж байрлана	ЗДТГ-ын зочид буудал
10-р сарын 10 (Баасан)	09:00–09:50	Өглөөний цай	ЗДТГ-ын зочид буудал
	10:00–10:30	Илтгэл 1: “Хамтарсан багийн гишүүдийн танилцуулга”	Чингэлтэй дүүрэг 16-р хороо, хамтарсан баг
	10:30–11:00	Илтгэл 2: “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлан”	Чингэлтэй дүүрэг 16-р хороо, хамтарсан баг
	11:00–11:30	Илтгэл 1: “Хамтарсан багийн гишүүдийн танилцуулга”	Норовлин сум Хамтарсан баг
	11:30–12:00	Илтгэл 2: “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлан”	Норовлин сум Хамтарсан баг
	12:00–13:00	Өдрийн хоол	Зохион байгуулагчид
	13:00–14:00	Төрийн байгууллага болон Шихи хутагаар танилцах	Зохион байгуулагчид
	14:00–16:00	Шихи хутаг төрсөн газар очих	Зохион байгуулагчид
	16:00–17:30	Спортын арга хэмжээ	ЕБС спорт заал
	17:30–18:30	Хүлээн авалт	Онон улз
10-р сарын 11 (Бямба)	10:00–11:00	Өглөөний цай, буцах хөдөлгөөн	Зочид буудал

**ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 16-Р
ХОРООНЫ ХАМТАРСАН БАГИЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС**

2025 оны 10 дугаар сарын 10 нд

Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны Хамтарсан багийн гишүүд 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Хэнтий аймгийн Норовлин суманд хүрэлцэн ирж, тус сумын хамтарсан багийн гишүүдтэй туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгууллаа.

Уулзалтын эхэнд Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны хамтарсан баг дүүргийнхээ товч танилцуулга, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж ажилласан ажлын арга туршлага, хороодын түвшинд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэсэн үр дүнгийн талаар илтгэл тавьж, мэдээлэл солилцов.

Норовлин сумын хамтарсан багийн танилцуулга хамтарсан багийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиглэл зэргийг дэлгэрэнгүй танилцуулсан. Засаг даргын орлогч сумынхаа ерөнхий танилцуулга, хүн амын бүтэц, онцлогыг танилцуулж амжиллав.

Үйл ажиллагааны үеэр хоёр тал хамтарсан багийн бүтэц, бүрэлдэхүүн, гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох тогтолцоог сайжруулах, хүүхдийн эрхийн зөрчлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үр дүнтэй арга хэмжээнүүд, шинэ санаачилгууд-ын талаар санал солилцож, туршлага хуваалцсан нь чухал ач холбогдолтой байлаа.

Мөн зочдод сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааг танилцуулж, Шихихутагт хөшөө, түүний төрсөн газар болон сумынхаа түүх, соёлын онцлог, бахархлыг дэлгэрэнгүй танилцуулан, газар оронтойгоо танилцуулж ажиллалаа.

Хүлээн авалтыг Онон улзын 2 давхарт хийж, өндөрлөсөн.

ТӨСӨВ:

Тус арга хэмжээний хүрээнд хоёр удаагийн хүлээн авалтад нийт **490,000 төгрөг**, Гарын бэлэгт 6 хүнд зориулан нийт **300,000 төгрөг**

Нийт-790,000 төгрөг зөрцуулсан.

ЗУРГАН ТАЙЛАН



ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ХАМТАРСАН БАГИЙН НАРИЙН БИЧИГ: *I. тугаа*/Г.АНХЗАЯА/